



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/185

Хэрлэн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны гуравдугаар хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.2.2 дахь арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоонд Пара бочигийн 2025 оны Улсын аварга шалгаруулах тэмцээнд аймгийн баг тамирчдыг зохион байгуулж оролцуулах зардалд 500,000 (таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг “Хувийн хэвшил, ТББ-ын оролцоотой ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжиж ажиллана” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч (Б.Түмэнжаргал)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

